


БАТЛАВ.
"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НОМИНЧУЛУУН

БАТЛАВ.
"ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-4"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ТӨМӨРХУЯГ

НҮҮРС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2021 он 1 сар 26 өдөр
2021.02.02

Дугаар 21/13-07
4/2021-09

Багануур дүүрэг

Нэг. Ерөнхий зүйл

1.1. "ДЦС-4" ТӨХК-ийн тоосон системтэй зуухны түлш бэлтгэх тоноглолд гэрээний 2.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн нүүрсийг гэрээнд заасан хуваарийн дагуу "Багануур" ХК-иас худалдах, "ДЦС-4" ТӨХК худалдан авч төлбөр тооцоо хийх ажиллагааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. "Багануур" ХК /цаашид "Худалдагч" гэх/ нь "ДЦС-4" ТӨХК /цаашид "Худалдан авагч" гэх/-д гэрээний хугацаанд 2000.0 мян.тонн нүүрсийг хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан үнээр нийлүүлнэ.

1.3. Худалдан авагч нь гэрээний хугацаанд 2000.0 мян.тн нүүрсийг хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан нөхцлөөр хүлээн авна.

1.4. Гэрээний биелэлтийн жилийн дүнг үндэслэн гэрээг хэрэгжүүлэхэд үр дүнтэй ажилласан Худалдагч, Худалдан авагчийн ажилтнуудыг гэрээнд оролцогч хоёр тал харилцан урамшуулж шагнаана. Хагас жилээр гэрээ дүгнэхдээ хоёр тал уулзалт тэмцээн зохион байгуулж урамшуулал олгож болно.

1.5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах аль нэг талын саналыг энэхүү гэрээнд оролцогч талуудын хамтарсан шийдвэр гаргаснаар мөрдөнө. Шийдвэрийг бичгээр гарган гэрээний нэгэн адил мөрдөнө.

Хоёр. Худалдагчийн үүрэг, эрх, хариуцлага

2.1. Худалдагч нь худалдан авагчийн технологийн шаардлагад тохирсон, сарын дундаж илчлэг нь 3360.0 ккал/кг-аас доошгүй, нийт хүхрийн хэмжээ нь 0.7 %-аас ихгүй, 0+200 мм-ийн бутармагтай, шавар, чулуулгын хольцын хэмжээ нь 3%-иас ихгүй, үнслэг, чийглэг нь MNS 3818-2001 стандартад зааснаас ихгүй нүүрсийг гэрээнд заасан хуваарийн дагуу нийлүүлэх үүрэгтэй.

Нүүрсний стандарт шинээр батлагдсан тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.

Худалдагчийг төлөөлж

Худалдан авагчийг төлөөлж

202

2.2. Худалдагч нь нүүрсийг вагонд нүүрс ачих паспортын дагуу ачиж өөрт суурилагдсан, хэмжүүрийн улсын шалгагчаар баталгаажсан вагон жингээр жигнэж, Худалдан авагчийн хаягаар баримтыг бүрдүүлж явуулна.

Вагон жингийн зөвшөөрөгдөх зөрүүг Худалдан авагчтай хамтран тогтоолгож зөвшөөрөгдөх зөрүүнд өөрчлөлт гарсан тохиолдолд Стандартчилал Хэмжил Зүйн Газраар зөвшөөрөгдсөн төмөр замын эталон жингээр хэмжүүрийн улсын шалгагчийн оролцоотойгоор тогтоолгоно.

2.3. Нүүрсний овор хэмжээ болон чанар зөрчигдөх, вагоны ачилт дундуур ирсэн тохиолдолд гарах хохирлыг Худалдагчийн чанарын инженер, эсвэл бусад эрх бүхий төлөөлөгч, Худалдан авагчийн төлөөлөгч газар дээр нь очиж гэрээнд холбогдох хүмүүсийг байлцуулан акт тогтоож шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл арбитр лабораторитой хамтарсан сорьц авч шинжилгээг үндэслэн шийдвэр гаргана.

2.4. Худалдагч нь өөрийн сорьц авах хүмүүсийг станц дээр ажиллуулах ба Худалдан авагчийн сорьц бэлтгэгчтэй хамтран хоёр талын хамтран гаргасан журмын дагуу цуваа бүрээс сорьц авч шинжлэн хоёр талын лабораторийн дунджаар илчлэгийг тооцно. Лаборатори бүр нь сарын дундаж илчлэгээ арифметикийн дунджаар гаргана.

2.5. Худалдагч нь ажил олгогчийн хувьд сорьц авагч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал, зааварчилгааны хэрэгжилт, сорьц авах техник ажиллагааны мөрдөлтийг бүрэн хариуцна.

2.6. Худалдагч нь сайтар цэвэрлэсэн вагонд нүүрс ачих ажлыг Төмөр замын өртөөтэй хамтран зохион байгуулна. Хэрэв төмөр, экскаваторын шүд, эд анги ачигдаж станцын тоноглолд гэмтэл учруулбал хоёр талын эрх бүхий техникийн комисс хамтран акт тогтоож шийдвэрлэнэ.

2.7. Худалдагч нь вагон жингийн дүнг бичсэн төмөр замын дагалдах бичиг болон падааныг 3 хувь үйлдэн, 1 хувь баримтыг ачааны хамт Худалдан авагчид илгээх үүрэгтэй.

2.8. Худалдагч нь гэрээнд заасан нүүрсээ нийлүүлж чадахгүй тохиолдолд 7-14 хоногийн өмнө, давагдашгүй хүчин зүйл гарвал 7 хоногийн дотор Худалдан авагчид албан ёсоор мэдэгдэнэ.

2.9. Худалдагч нь Худалдан авагчийн төлөөлөгчийг ажлын байр, дотоод холбоогоор хангана. Худалдан авагчийн төлөөлөгчийн гэрээний шаардлага хангахгүй гэж үзсэн нүүрсийг Худалдан авагчид хаяглахгүй байх үүрэгтэй.

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



2.10. Худалдагч нь Худалдан авагчийн шинэчилсэн зуухны тээрэмд нүүрстэй хамт их хэмжээний шавар, чулуулаг, төмөр оруулж тоноглолд гэмтэл учруулахгүй байх үүрэгтэй.

2.11. Худалдан авагч нь гэрээний хавсралтанд заасан хуваарийг өөрчлөн захиалгаа өгсөнөөс шалтгаалан гэрээний биелэлтэнд сөргөөр нөлөөлсөн бол үүнээс гарах хохирлыг Худалдагч хариуцахгүй.

2.12 Худалдан авагчаас шалтгаалан гэрээний хавсралтанд заасан хуваарийн дагуу нүүрс худалдан аваагүй бол Худалдагч нөхөн нийлүүлэхгүй байж болно.

2.13 Худалдагч талаас шалтгаалан нүүрсээ хуваарийн дагуу нийлүүлж чадаагүй тохиолдолд Худалдан авагчийн саналыг үндэслэн нийлүүлээгүй нүүрсийг дараа саруудад нөхөн нийлүүлнэ.

2.14 Худалдан авагч нь нүүрсний үнийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд 7 хоногийн өмнө албан ёсоор мэдэгдэж нүүрс нийлүүлэлтийг хязгаарлах эрхтэй.

2.15. Худалдагч нь нүүрсийг вагоны даацанд хүргэж ачих үүрэг хүлээнэ.

2.16. Худалдан авагч нь ажилчдынхаа ахуйн хэрэгцээнд зориулж нүүрс олгох шийдвэр гаргаж, Худалдагчид цэгийн нүүрс ачиж нийлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд заасан хугацаанд нь цэгийн нүүрс ачиж нийлүүлнэ. Хүсэлт гаргасны дагуу ачигдсан нүүрсний хэмжээ гэрээний хавсралтын хуваарьт нөлөөлөхгүй.

2.17 Худалдагч нь худалдан авагчийн технологийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нүүрс бутлан ачих хэсгээр орж бутлагдсан нүүрсийг жилийн турш нийлүүлнэ. Хэрэв худалдагч талын нүүрс бутлан ачих хэсэгт техник, технологийн саатал үүссэн тохиолдолд худалдан авагч талд мэдэгдэж зөвшилцсөний үндсэн дээр цэгийн нүүрс нийлүүлэх асуудлыг тохиролцоно.

2.18 Худалдан авагч нь хоёр өөр уурхайн нүүрсийг хольж технологийн хэрэгцээнд ашиглаж байгаа тул захиалсан нүүрсийг талуудын тохирсон хуваарийн дагуу өдөр тутам жигд ачиж илгээнэ.

Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг, хариуцлага


3.1. Худалдагчаас ирүүлсэн нүүрсийг хүлээн авахдаа вагоны илгээлтийн баримтын дагуу дагалдах бичиг, бичигдсэн падааны дагуу вагоны дугаар, бутармаг, жингээр нь тулган хүлээн авна.

3.2. Худалдагчаас нийлүүлэгдэж байгаа нүүрсийг Стандартчилал Хэмжил Зүйн Газраар зөвшөөрөгдсөн төмөр замын эталон жингээр баталгаажсан вагон жингээр жигнэж хүлээн авна.

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



3.3. Худалдагчийн нийлүүлсэн нүүрс гэрээний 2.1-д заасан шаардлага хангаагүй буюу үүний улмаас хэрэглэгчийн тоноглолд саатал, хохирол гарах тохиолдолд Худалдагчийн төлөөлөгчийг байлцуулан дор дурьдсан журмаар асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

3.3.1. 3250 ккал/кг-аас доош илчлэгтэй нүүрсийг хүлээж авахгүй, нүүрстэй вагоныг Худалдагчийн төлөөлөгчид хүлээлгэн өгч буцаана. Хаяг солихтой холбогдон гарах бүх тээврийн зардлыг Худалдагч хариуцна.

3.3.2. 3250 ккал/кг-аас дээш илчлэгтэй нүүрсийг Худалдан авагчийн техникийн шаардлага хангасан гэж үзэж ямар нэгэн нэмэгдэл зардал гаргахгүйгээр хүлээн авна.

3.3.3. Худалдан авагч нь нүүрсийг багажит анализийн аргаар вагон дээр шууд тодорхойлсон тохиолдолд лабораторит шинжлэн шинжилгээний дүнг баталгаажуулна.

3.3.4. Нүүрсний чанартай холбоотой маргааныг таслах зорилгоор Худалдагч, Худалдан авагч хамтран сорьц авч шинжилж эцсийн шийдвэр гаргаж болох бөгөөд шинжилгээний дүнг гартал зогссон вагоны ашиглалт, таталт тавилтын хөлс, хаяг солилтын хөлс, холбогдож гарах бусад зардлыг буруутай тал хариуцна.

3.3.5. Нийлүүлэгдсэн нүүрсний шавар чулуулгийн хольцын хэмжээ гэрээний 2.1-д зааснаас их байвал тооцоо хийхдээ тухайн сард нийлүүлсэн нүүрсний хэмжээнээс хасаж тооцно.

3.3.6. Нийлүүлэгдсэн нүүрсний шавар чулуулгын хольцын хэмжээ гэрээний 2.1-д зааснаас их байснаас мөн экскаваторын шүд, төмөр элдэв хольц нүүрстэй хамт ачигдан ирж Худалдан авагчийн тоноглолд гэмтэл учруулж, хохирол гарсан бол гэмтлийн актыг Худалдагчид тавьж хохирлыг улирал бүр барагдуулна.

3.4. Худалдан авагч нь уурхайд өөрийн төлөөлөгчийг ажиллуулж нүүрсний чанар, ачилт, жигнэлтэнд хяналт тавих эрх эдэлнэ.

3.5. Энэхүү гэрээний хавсралтанд заасан нүүрс нийлүүлэх хуваарийг үндэслэн Худалдагчтай тодотгол хийсний дараа Худалдан авагч нь сар бүрийн 28-ны дотор вагон захиалах төлөвлөгөөт гэрээг УБТЗ-ын Тээвэр зохион байгуулалтын албанд өгч батлуулж ажиллана. Нүүрсний тээвэрлэлтэнд зориулсан вагоноор хангах асуудлыг УБТЗ-д тавьж шийдвэрлүүлж ажиллана.

3.6. Диспетчерийн Үндэсний Төв /ДҮТ/ ХК-иас өгсөн цахилгаан, дулааны хэрэглээний өсөлтөөс болж Худалдан авагч нь гэрээний хавсралтанд заасан хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд Худалдагчтай

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



зөвшилцсөний дараа төмөр замын байгууллагад вагоны захиалга өгнө. Харин өвлийн их ачааллын үед нөөцлөх нүүрсийг ЭХЯмнаас баталсан тохиолдолд уг хуваарийг Худалдагчтай тохиролцон мөрдөнө.

3.7. Нийлүүлэгдсэн нүүрсний бодит ба тооцоот илчлэгний зөрүүг улиралд нэг удаа тооцож худалдан авагч нь шаардлагатай гэж үзвэл нүүрсний захиалгын хуваарьт өөрчлөлт оруулах эрх эдэлнэ.

3.8. Худалдан авагчийн вагон жинд хэмжүүрийн улсын шалгагч баталгаажуулалт хийх үед уурхайн чанарын инженерыг байлцуулж протоколд гарын үсэг зуруулна.

3.9. Багануурын уурхайн нүүрсийг жигнэх бүрд уурхайн сорьц авагчийг байлцуулж жигнэлтийн хуудсанд гарын үсэг зуруулна.

Дөрөв. Төлбөр, тооцоо

4.1. Тухайн сарын эхний өдрийн 00 цагаас сарын сүүлчийн өдрийн 24.00 цагийн хооронд ачсан нүүрс вагоны тоог төмөр замын явуулах өртөөний /Багануур өртөө/ календарийн тэмдгийг ачааны падаанд дарсан он, сар, өдрөөр авч сарын тооцоог 2 тал хийнэ.

4.2. Сард нийлүүлсэн нүүрсний жинг тооцохдоо:

4.2.1. Хоёр талын вагон жин ажиллагаатай байгаа тохиолдолд худалдан авагчийн баталгаажсан вагон жингийн заалтаар тооцоо хийнэ.

4.2.2. Аль нэг талын вагон жин ажиллаагүй тохиолдолд хэвийн ажиллагаатай байгаа /баталгаажсан/ вагон жингийн заалтаар даацыг тооцно.

4.2.3. Хоёр талын вагон жин ажиллаагүй тохиолдолд сүүлчийн хоёр сарын хэмжилтийн дундаж жингээр нэг вагоны даацыг тооцно.

4.3. Төмөр замын тээврийн хөлсийг станц, төмөр замын өртөөний хооронд сар бүр хийсэн тооцоог үндэслэн Худалдан авагч төлж нүүрс тээврийн захиалга өгөх нөхцлийг бүрдүүлнэ. Төмөр замд төлбөр хийгдээгүйн улмаас вагон хангалтаас үүдсэн хохирлыг Худалдан авагч бүрэн хариуцна. Нүүрс болон вагон захиалганд зохицуулалт хийвэл харилцан хоорондоо урьдчилан мэдэгдэнэ. Тээврийн хөлсийг Худалдагч тал явуулах өртөөнд төлөхгүй.

4.4. Энэхүү гэрээний хавсралтанд заасан хуваарийн дагуу Худалдан авагч тухайн сард авсан нүүрснийхээ үнийг 7 хоног бүр төлж ажиллана.

Урьд сарын дутуу төлөлтийг төлж дууссаны дараа тухайн сарын төлбөр хийгдсэн гэж үзнэ.

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



УУ
ЗҮР
102

4.5. Төлбөрийг хугацаандаа хийгээгүй бол үлдэгдэл төлбөрийн дүнгээр хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,15 хувиар бодож Худалдагчид алданги төлнө.

4.6. Худалдагчийн буруугаас нүүрс нийлүүлэлт, татан авалтын гэрээ тасарсан тохиолдолд дутуу нийлүүлсэн нүүрсний үнийн дүнгийн 0.15 хувиар бодож Худалдан авагчид алданги төлнө.

4.7. Төлбөр төлөлт болон нүүрс нийлүүлэлтийн дутуугаас тооцох алдангийг хагас, бүтэн жилийн гэрээ дүгнэх хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Холбогдох дээд газрын шийдвэрээр "ДЦС-4" ТӨХК-ийн үйлдвэрлэлийн программ өөрчлөгдсөн тохиолдолд нүүрсний хуваарийн зөрчилд харилцан алданги хүлээхгүй. Худалдагч нь мөн адил Худалдан авагчийн энэ эрхийг эдэлж алданги хүлээхгүй байж болно. Эдгээр асуудлыг харилцан судалж хүндэтгэх шалтгаантай бол хөнгөлөх тухай бичгэн шийдвэр гаргана.

4.8. Худалдагч, Худалдан авагчийн буруутай бус шалтгаанаар нүүрс нийлүүлэлт, татан авалтын гэрээ тасарсан тохиолдолд төмөр замд нүүрс тээвэрлэлтийн талаар хамтарсан акт бичнэ.

4.9. Нийлүүлэх нүүрсний суурь илчлэгийг 3360 ккал/кг-аар тооцоонд авах бөгөөд 1 тонн технологийн дамжлагын нүүрсний үнийг 33500 төгрөг, 1 ккал/кг-ын үнийг 9.9702 төгрөгөөр, 1 тонн цэгийн нүүрсний үнийг 32500 төгрөгөөр, 1ккал/кг-ын үнийг 9.6726 төгрөгөөр тус тус тооцно. Нэмэгдсэн өртгийн албан татварыг нэмж тооцно.

Нүүрсний илчлэг 3360 ккал/кг-аас доош орсон буюу дээш гарсан илчлэгтэй нүүрсний үнийг тооцохдоо тухайн сарын дундаж илчлэгийг 1ккал/кг-ын үнээр үржүүлж бодно. 3550 ккал/кг-аас дээш илчлэгтэй нүүрсэнд илчлэгийн зөрүүг тооцохгүй.

4.10. Нүүрсний үнэд эрх бүхий дээд газруудаас өөрчлөлт оруулсан үед өөрчлөгдсөн үнийг мөрдөж ажиллана.


4.11. Харилцан хүлээх хариуцлагаас үүдэн гарах хохирлын тооцоог улирал бүр хийнэ. Сар бүрийн нүүрс нийлүүлэлт тооцооны дүнг хэлэлцсэн протокол болон хохирол саатлын актыг Худалдагчийн тооцооны ня-бо, чанарын инженер нар танилцаж гарын үсэг зурна. Гарсан хохирлын актыг тухайн улирлын аж ахуйн гэрээг дүгнэхдээ хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд баталгаажуулан харилцан суутгал хийж тооцно.

4.12. Нүүрсний сарын дундаж илчлэгийг тодорхойлохдоо тухайн сард Худалдагч болон Худалдан авагчийн хийсэн шинжилгээний дүнгийн дунджаар тооцоо хийнэ. Чанарын хэлбэлзэлтэй нүүрсний илчлэгийг сарын дундажид оруулж тооцно. /Хэрэв Худалдан авагч нүүрсийг буулгаж авсан бол/

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



4.13. Талууд сарын хуваарийн дагуу вагон захиалалт, нийлүүлэлт, татан авалтыг шуурхай гүйцэтгэж гэрээний үүргээ биелүүлэх ба энэ талаар аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг буруутай тал нь хүлээнэ.

4.14. Худалдагчийн албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Худалдагчийн өмнөөс СЯ, ГЕГ-т хийх төсвийн болон гаалийн татварын төлбөрүүдийг үйлдэж тооцоонд оруулна.

Суутган тооцсон тухай протокол үйлдэж тооцоонд оруулна.

Тав. Гэрээний бусад нөхцөл

5.1. Талууд өөрсдийн захиалгаар арбитр лабораторийн нэмэлт шинжилгээ хийлгэвэл шинжилгээний үнийг захиалсан тал төлнө.

5.2. Цаг агаарийн дулаарал, хэрэглэгчийн дулаан цахилгааны хэрэглээний хязгаарлалтаас болж Худалдагчийн борлуулалт тасарч үүний улмаас нүүрсний хэрэглээ багасвал гэрээг Худалдан авагчийн татан авсан нүүрсний хэмжээгээр биелсэнд тооцно. Торгууль хүлээлгэхгүй.

Аль нэг талдаа төлөгдөх алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийт төлбөрийн 20 хувиас хэтэрч болохгүй.

5.3. Хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний төлөвлөгдөөгүй өсөлтөөс болж аж ахуйн гэрээнээс илүү нүүрс Худалдан авагчийн технологийн хэрэгцээнд зайлшгүй шаардагдвал 20 хоногийн өмнө Худалдагчид мэдэгдэн энэхүү гэрээний хавсралтанд заасан нүүрсний хуваарьт протоколоор өөрчлөлт оруулж мөрдөнө. Нүүрсний үнийг гэрээнд заасан үнээр тооцно.

5.4. Технологийн саатал, аваарь осол гарах, техникийн хүндрэл учрах зэрэг тохиолдолд гэрээ хийсэн талуудын төлөөлөгчид хамтран хэлэлцэж саадыг даван туулах, гэрээний заалтанд өөрчлөлт оруулах шийдвэрийг бичгээр гаргана.

Энэ шийдвэр нь гэрээний эцсийн биелэлтэнд нөлөөлөхгүй.

5.5. Нүүрс нийлүүлэлт нь вагон хангамжаас шалтгаалах тул тухайн сард төмөр замаас нийлүүлэн ачсан вагоны хэдэн хувийг Худалдан авагчид илгээсэн, Худалдан авагч тухайн сард нийт вагоны хэдэн хувийг захиалсан харьцааг үндэслэн Худалдагч, төмөр замын хэн буруутайг тогтооно.

5.6. Энэхүү гэрээ нь харилцан баталсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.7. Талууд гэрээний заалтуудыг тогтмол мөрдөж ажиллах бөгөөд зөрчигдсөн тохиолдолд хохирогчийн гомдлыг үндэслэн хамтарсан шийдвэр гаргаж байна. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл шүүхэд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



5.8. Гэрээг улирал бүр дүгнэх бөгөөд I, III улиралд худалдагч, II, IV улиралд Худалдан авагч хариуцан нөгөө талдаа очиж дүгнэнэ. Энэхүү гэрээ нь 2021 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 31-ныг дуустал хүчин төгөлдөр мөрдөгдөнө.


5.9. Гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн өдрөөс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр байх ба цаашид сунгах эсэх асуудлыг хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээнд оролцогч аль нэг тал нь гэрээг үргэлжлүүлэн мөрдөхөөс татгалзаагүй тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр гэж үзнэ.

5.10. Энэхүү гэрээ нь Худалдагч, Худалдан авагчид тус бүр 2 хувь хадгалагдах бөгөөд гэрээ дүгнэсэн акт, протоколын хувиудыг талууд өөрсдөө хадгална.

Гэрээ дүгнэсэн акт, протокол нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Д.ТҮВШИНЖАРГАЛ

Тэргүүн дэд захирал

СЭЗБХ-ийн дарга



Д.БОЛД

Үйлдвэр борлуулалтын албаны дарга




Г.БЯМБАЖАРГАЛ

Хуулийн зөвлөх



С.СЭРГЭЛЭН

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Б.ГАНХУЯГ


Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер

Ерөнхий инженерийн орлогч




Р.ГАНБАТ

СБХ-ийн дарга, Ерөнхий ня-бо



Д.ТӨМӨРТОГОО

Нүүрсний нийлүүлэлт, гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн



Ү.БОЛД


Хянасан:



Ч.БЯМБАСҮРЭН

Хуулийн зөвлөх

Гэрээний мэргэжилтэн



С.ДОНИД


2021 оны сарын өдөр

2021 оны ⁰¹ сарын ¹⁴ өдөр

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



ТАЛУУДЫН ХАЯГ:

Улаанбаатар хот. Багануур дүүрэг
“Багануур” ХК

Утас: 70213145

Факс: 70213130

Данс: ХХБанк 499031495

ХААН Банк 5750009138

ХАС Банк 5000199440

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг
“ДЦС-4” ТӨХК

Утас: 70171284, 70002351

Факс: 70001374, 70002351

Данс: ХХБ 806-р салбар 406001049

ХААН Банк 5038008126

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



Гэрээ
хариуц
ажилт
үлд

9/2001-09

ТООТ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

БАТЛАВ. "БАГАНУУР" ХК-ийн гүйцэтгэх захирал
 Э.НӨМИНЧУЛУУН



БАТЛАВ. "ДЦС-4" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал
 У.ТӨМӨРХУЯГ

У.Төмөрхуяг

2021 онд "Багануур" ХК-иас "ДЦС-4" ТӨХК-д нийлүүлэх нүүрс, төлбөрийн хуваарь

| д/д | нэгж | нийт | I улирал | | | II улирал | | | III улирал | | | IV улирал | | | | | | |
|-----|-----------------|---------|----------|--------|--------|-----------|--------|--------|------------|---------|--------|-----------|--------|---------|--------|--------|--------|---------|
| | | | I | II | III | дүн | IY | Y | YI | дүн | YII | YIII | IX | дүн | X | XI | XII | дүн |
| 1 | нүүрс | 2000.0 | 200.0 | 180.0 | 190.0 | 570.0 | 160.0 | 145.0 | 130.0 | 435.0 | 125.0 | 145.0 | 160.0 | 430.0 | 190.0 | 185.0 | 190.0 | 565.0 |
| 2 | нүүрсний төлбөр | 76770.0 | 7677.0 | 6909.3 | 7293.2 | 21879.5 | 6141.6 | 5565.8 | 4990.1 | 16697.5 | 4798.1 | 5565.8 | 6141.6 | 16505.6 | 7293.2 | 7101.2 | 7293.2 | 21687.5 |

Тайлбар: 1 тн нүүрсний үнийг 3500 ккал/кг илчлэгтэй, технологийн дамжлагын буталсан нүүрсний үнээр, 38385 төгрөгөөр /НӨАТ 10%/ тооцов.

"БАГАНУУР" ХК-ийн ҮБА-НЫ дарга

[Signature]

Т.Бямбажаргал

"ДЦС-4" ТӨХК-ийн ЕИО

[Signature] Р.Ганбат

сан